



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/97

Бат-Өлзий сум

Хөдөө аж ахуйн ээлжит тооллогын  
комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "л" заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн "Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах тухай" 74 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг зохион байгуулж явуулах сумын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: Н.Түвшин (тоологч)

Г.Сугар (тоологч)

Б.Янжиндулам (тоологч)

Ж.Батмөнх (тоологч)

М.Мягмаржав (тоологч)

Багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2. Хөдөө аж ахуйн ээлжит тооллогын бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг ханган, тооллогыг тогтоосон хугацаанд заавар, журмын дагуу чанартай явуулж, дүнг нэгтгэн, аймгийн комисст 2022 оны 07 дугаар сарын 04-ны дотор хүлээлгэн өгөхийг Комиссын дарга (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН